



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 9 сарын 27 өдөр

Дугаар 167

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад нэр дурдсан 2 компанийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах хүсэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлээгүй тохиолдолд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг хавсралтад нэр дурдсан хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 9 дүгээр сарын 27-ны
өдрийн 167 дугаар тогтоолын хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгө оруулалтын менежментийн нэрс	Байршил /аймаг/	Тусгай зөвшөөрөл авсан огноо
1.	"Агниста инвестмэнт" ХХК	Улаанбаатар	2016.01.20
2.	"Бодь инвест" ХХК	Улаанбаатар	2014.05.21